

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК



САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkhorgill@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн аудитор: Г.Батбаатар
Утас: 99012627 Цахим хаяг:
khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/144
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН УУЛ
СУМЫН ХҮҮХДИЙН 1-Р
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.АЗБАЯР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 25,596.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэсэн, мөн ИТХ-ын тогтоолоор 7,085.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж устгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн ажилтанд олгосон урамшуулал, төсвийн хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 6,803.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, зөрчлийг дахин давтахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Цагаан уул сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2024 онд аймгийн Боловсролын газрын даргатай гэрээ байгуулан ажиллаж, хэрэгжилтийг 76.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6705021841

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Санхүү байдлын тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>198,511,684.70</u> | <u>244,227,726.69</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 126,481,109.70 | 156,739,828.69 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 126,481,109.70 | 156,739,828.69 |
| 3121 | Төгрөг | 126,481,109.70 | 156,739,828.69 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 126,481,109.70 | 156,739,828.69 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 72,030,575.00 | 87,487,898.00 |
| 351 | Түүхий эд материал | 20,493,433.00 | 32,821,833.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 20,212,333.00 | 32,456,833.00 |
| 35130 | Эм боох материал | 281,100.00 | 365,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 47,825,326.00 | 53,121,065.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,870,800.00 | 2,439,680.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,496,509.00 | 10,198,358.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 650,000.00 | 770,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,022,100.00 | 1,376,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 14,318,965.00 | 14,687,975.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 20,466,952.00 | 23,648,452.00 |
| 35600 | Мал амьтад | 3,711,816.00 | 1,545,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>392,838,016.55</u> | <u>399,016,294.96</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 392,838,016.55 | 399,016,294.96 |
| 392 | Биет хөрөнгө | 380,566,016.55 | 386,744,294.96 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -87,049,232.80 | -99,561,796.27 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 78,321,333.08 | 91,908,502.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -27,713,278.15 | -31,465,086.77 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,097,606.00 | 21,709,806.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8,814,001.51 | -9,433,603.54 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 24,130,712.00 | 30,441,712.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,592,680.27 | -3,040,796.74 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>591,349,701.25</u> | <u>643,244,021.65</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>460,800.00</u> | <u>00.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 460,800.00 | 00.00 |
| 413 | Өглөг | 460,800.00 | 00.00 |
| 4136 | Бусад өглөг | 460,800.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 460,800.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>590,888,901.25</u> | <u>643,244,021.65</u> |
| 51 | Засгийн газрын хувь эрөлцөө | 590,888,901.25 | 643,244,021.65 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 146,142,124.31 | 198,497,244.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 52,355,120.40 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>591,349,701.25</u> | <u>643,244,021.65</u> |

**Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 534,315,800.00 | 743,651,469.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,521,600.00 | 40,695,169.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,521,600.00 | 40,695,169.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 70,000.00 | 570,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 570,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.00 | 00.00 |
| 13 | ТУСПАМЖ, САНХҮҮЖИПТИЙН ОРЛОГО | 531,794,200.00 | 702,956,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 486,062,700.00 | 656,643,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 486,062,700.00 | 656,643,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 45,731,500.00 | 46,312,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,731,500.00 | 46,312,900.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 469,352,997.77 | 691,296,348.60 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 469,352,997.77 | 691,296,348.60 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 465,161,976.49 | 687,872,748.67 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 303,050,200.00 | 501,578,999.05 |
| 210101 | Үндсэн цалин | 217,973,338.00 | 330,717,207.05 |
| 210102 | Нэмэгдэл | 76,624,261.00 | 164,258,592.00 |
| 210104 | Урамшуулал | 8,452,601.00 | 6,603,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл | 38,170,860.30 | 62,398,486.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,039,761.91 | 42,856,300.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,063,502.00 | 4,796,138.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,424,401.62 | 2,451,849.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 594,496.54 | 2,287,337.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,048,698.23 | 10,006,859.98 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 37,149,878.72 | 37,769,400.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,603,982.72 | 3,981,142.07 |
| 210302 | Түлш, халаалт | 33,990,896.00 | 32,828,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 555,000.00 | 960,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,979,999.00 | 6,540,046.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 907,800.00 | 131,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 849,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,223,199.00 | 5,449,046.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 960,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 33,118,655.00 | 40,625,490.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 31,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,118,655.00 | 40,594,390.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,536,500.00 | 4,475,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,536,500.00 | 4,475,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 745,000.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 745,000.00 | 450,000.00 |

Аудитын код: ХӨА-2025/170/НА-СТА-ТЗШ

**Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | |
|--------|--|----------------------|----------------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 40,410,883.47 | 34,034,926.59 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,427,450.00 | 10,389,316.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлтийн дадлага хийх | 1,830,800.00 | 3,227,720.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,152,633.47 | 20,417,890.59 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,191,021.28 | 3,423,599.93 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,191,021.28 | 3,423,599.93 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,191,021.28 | 3,423,599.93 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>64,962,802.23</u> | <u>52,355,120.40</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>64,962,802.23</u> | <u>52,355,120.40</u> |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь эрэлцсөний нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 95,678,686.95 | 349,428,767.99 | -5,129,042.43 | 439,978,412.51 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 108,264.50 | 108,264.50 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 95,678,686.95 | 349,428,767.99 | -5,020,777.93 | 440,086,677.01 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -1,998,048.22 | -1,998,048.22 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 95,678,686.95 | 349,068,089.99 | 146,142,124.31 | 590,888,901.25 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 95,678,686.95 | 349,068,089.99 | 146,142,124.31 | 590,888,901.25 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 95,678,686.95 | 349,068,089.99 | 146,142,124.31 | 590,888,901.25 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 52,355,120.40 | 52,355,120.40 |
| 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 95,678,686.95 | 349,068,089.99 | 198,497,244.71 | 643,244,021.65 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | <u>531,864,200.00</u> | <u>703,526,300.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 70,000.00 | 570,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 70,000.00 | 570,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 70,000.00 | 570,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 570,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.00 | 00.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 531,794,200.00 | 702,956,300.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 486,062,700.00 | 656,643,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 486,062,700.00 | 656,643,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 45,731,500.00 | 46,312,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 45,731,500.00 | 46,312,900.00 |

Аудитын код: ХӨА-2025/170/НА-СТА-ТЗШ

**Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | |
|--------|--|----------------|----------------|
| 2 | НИЙТ ЗАРПАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 439,042,758.30 | 673,267,581.01 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 439,042,758.30 | 673,267,581.01 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 434,851,737.02 | 669,843,981.08 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 303,050,200.00 | 501,578,999.05 |
| 210101 | Үндсэн цалин | 217,973,338.00 | 330,717,207.05 |
| 210102 | Нэмэгдэл | 76,624,261.00 | 164,258,592.00 |
| 210104 | Урамшуулал | 8,452,601.00 | 6,603,200.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,170,860.30 | 62,398,486.96 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,039,761.91 | 42,856,300.46 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,063,502.00 | 4,796,138.84 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,424,401.62 | 2,451,849.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 594,496.54 | 2,287,337.81 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,048,698.23 | 10,006,859.98 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,121,878.72 | 37,889,400.07 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,603,982.72 | 3,981,142.07 |
| 210302 | Түлш, халаалт | 32,962,896.00 | 32,948,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 555,000.00 | 960,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,564,750.00 | 40,823,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 34,564,750.00 | 40,823,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,418,600.00 | 4,999,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,418,600.00 | 4,999,900.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 745,000.00 | 450,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 745,000.00 | 450,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,780,448.00 | 21,703,295.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,889,648.00 | 17,259,095.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,890,800.00 | 4,444,200.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,191,021.28 | 3,423,599.93 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 4,191,021.28 | 3,423,599.93 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,191,021.28 | 3,423,599.93 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 92,821,441.70 | 30,258,718.99 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 92,821,441.70 | 30,258,718.99 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 33,659,668.00 | 126,481,109.70 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 126,481,109.70 | 156,739,828.69 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|--|-----------------------|-----------------------|-----------------------|--------------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 126,481,109.70 | | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 761,366,400.00 | 626,954,681.01 | 134,411,718.99 | 82.35 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 761,366,400.00 | 626,954,681.01 | 134,411,718.99 | 82.35 |
| Бараа, үйлчилгээний зардал | 761,366,400.00 | 626,954,681.01 | 134,411,718.99 | 82.35 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 606,194,600.00 | 501,578,999.05 | 104,615,600.95 | 82.74 |
| Үндсэн цалин | 417,707,800.00 | 330,717,207.05 | 86,990,592.95 | 79.17 |
| Нэмэгдэл | 182,722,100.00 | 164,258,592.00 | 18,463,508.00 | 89.90 |
| Урамшуулал | 5,764,700.00 | 6,603,200.00 | (838,500.00) | 114.55 |
| Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 70,099,200.00 | 62,398,486.96 | 7,700,713.04 | 89.01 |
| Тэтгэврийн даатгал | 47,669,100.00 | 42,856,300.46 | 4,812,799.54 | 89.90 |
| Тэтгэмжийн даатгал | 5,606,500.00 | 4,796,138.84 | 810,361.16 | 85.55 |
| ҮОМШӨ ний даатгал | 2,803,800.00 | 2,451,849.87 | 351,950.13 | 87.45 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,803,800.00 | 2,287,337.81 | 516,462.19 | 81.58 |
| Эрүүл мэндийн даатгал | 11,216,000.00 | 10,006,859.98 | 1,209,140.02 | 89.22 |
| Нормативт зардал | 51,841,800.00 | 40,823,900.00 | 11,017,900.00 | 78.75 |
| Хоол, хүнс | 51,841,800.00 | 40,823,900.00 | 11,017,900.00 | 78.75 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 2,534,800.00 | 450,000.00 | 2,084,800.00 | 17.75 |
| Мэдээллийн технологийн зардал | 2,534,800.00 | 450,000.00 | 2,084,800.00 | 17.75 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 30,696,000.00 | 21,703,295.00 | 8,992,705.00 | 70.70 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 23,813,100.00 | 17,259,095.00 | 6,554,005.00 | 72.48 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,882,900.00 | 4,444,200.00 | 2,438,700.00 | 64.57 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 761,366,400.00 | 657,213,400.00 | 104,153,000.00 | 86.32 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 656,770,500.00 | 656,643,400.00 | 127,100.00 | 99.98 |
| Улсын төсвөөс санхүүжих | 656,770,500.00 | 656,643,400.00 | 127,100.00 | 99.98 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 104,595,900.00 | 570,000.00 | 104,025,900.00 | 0.54 |

Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын хүүхдийн 1-р цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | |
|---|----------------|----------------|------------------|--------|
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 70,000.00 | 570,000.00 | (500,000.00) | 814.29 |
| Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 104,525,900.00 | - | 104,525,900.00 | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 126,481,109.70 | (126,481,109.70) | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 156,739,828.69 | (156,739,828.69) | - |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---------------|---------------|--------------|--------|
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 46,312,900.00 | 42,889,300.07 | 3,423,599.93 | 92.61 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 46,312,900.00 | 42,889,300.07 | 3,423,599.93 | 92.61 |
| Бараа, үйлчилгээний зардал | 46,312,900.00 | 42,889,300.07 | 3,423,599.93 | 92.61 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 41,312,900.00 | 37,889,400.07 | 3,423,499.93 | 91.71 |
| Гэрэл цахилгаан | 5,500,000.00 | 3,981,142.07 | 1,518,857.93 | 72.38 |
| Түлш, халаалт | 32,312,900.00 | 32,948,258.00 | (635,358.00) | 101.97 |
| Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 960,000.00 | 2,540,000.00 | 27.43 |
| Эд хогшил худалдан авах | 5,000,000.00 | 4,999,900.00 | 100.00 | 100.00 |
| Урсгал засвар | 5,000,000.00 | 4,999,900.00 | 100.00 | 100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 46,312,900.00 | 46,312,900.00 | - | 100.00 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 46,312,900.00 | 46,312,900.00 | - | 100.00 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 46,312,900.00 | 46,312,900.00 | - | 100.00 |

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар үндсэн хөрөнгө, бараа материал, төсвийн зарцуулалттай холбоотой 3 зөрчил илрүүлж 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Аудитын залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой залруулга хийгээгүй болно.

5.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Аудитын код: ХӨА-2025/170/НА-СТА-ТЗШ

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

Тус цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн Б/14 тушаалаар байгууллагын нярав Б.Баасанчулуунд 1 сарын үндсэн цалин 1,042.0 мянган төгрөгийн балансын урамшуулал олгохдоо батлагдсан журам, шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын үр дүнг үнэлээгүй байгаа тодорхойгүй зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23.2.Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглох, Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" зөрчигдсэн.

Өгсөн зөвлөмж:

Балансын урамшууллыг олгох талаар дотоод журамд зааж, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас олгож байх зөвлөмж хүргүүлэв.

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинжтэй 5,761.5 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 10.1.Үндсэн хөрөнгө нь бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэд ашиглах, бусдад түрээслүүлэх, эсхүл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм гэсэн заалт, "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын данснаас хасч үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, элэгдэл тооцох зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Урамшуулал олгох шийдвэр гаргахдаа ажлын үр дүнг бодит байдал нийцүүлэн үнэлээгүй зөрчил илэрсэн. | 1 | 1,042.0 | | | | | 1 | 1,042.0 |
| Үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. | 1 | 5,761.5 | | | | | 1 | 5,761.5 |
| Дүн | 2 | 6,803.5 | | | | | 2 | 6,803.5 |